



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 30 өдөр

Дугаар А/19

Улаанбаатар хот

Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд  
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төвд шаардлагатай тоног төхөөрөмж (БХД)” нийлүүлэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд томилогдсон 2 дугаар хорооны иргэн Д.Боломж нь ар гэрийн шалтгаанаар Бүгд найрамдах Солонгос улс руу явсан тул 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/255 дугаар захирамжаар томилогдсон гишүүний үүргээс чөлөөлж 2 дугаар хорооны иргэн П.Борыг нөхөн томилсугай.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД